

БУДДЫН ЁС ЗҮЙ ДЭХ АМЬТНЫГ ХАМГААЛАХ АСУУДАЛД

Д.Оюунгэрэл, доктор (Ph.D)

МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш

С.Дэмбэрэл, докторант

МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш

Товч утга: Орчин үеийн хэрэглээний ёс зүйн нэгэн чухал чиглэл бол био ёс зүй бөгөөд хүн төрөлхтний өмнө тулгарч буй бэрхшээл хүндрэлтэй асуудлыг хэрхэн даван туулах арга замыг эрэлхийлдэг болно. Тухайлбал, ургамал амьтны олон янз байдал, анагаах ухааны ёс зүй, био аюулгүй байдал, невро ёс зүй, амьтны эрх, генийн инженерчлэл, үүдэл эс, үр хөврөл шилжүүлэн суулгах, эд эсийн клонинг, бэлгийн цөөнх зэрэг олон асуудлыг нэрлэж болно. Эдгээрээс тус өгүүлэлд амьтныг хамгаалах ёс зүйд (animal ethics) амьтны жам ёсны эрх, түүнийг хэрхэн хамгаалах тухай өргөн хүрээтэй хэлэлцэгдэж буй өнөө үед буддын ёс зүйд уг асуудлыг хэрхэн авч үздэгийг тодруулна. Хүн төрөлхтний соёл, сэтгэлгээний салиггүй нэг хэсэг болсон буддизм нь номлол сургаал, зан үйлээрээ дамжуулан байгаль-хүн хоорондын харилцааг тодорхойлж, чиглүүлж ирсэн байна.

Буддын ёс зүйн үзэл нь энэрэн нигүүлсэхүйн зарчим дээр тулгуурлаж, эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд байж, хорхой шавжаас эхлээд бүх амьтныг хайрлаж хамгаалахыг сургадаг. Монголчуудын дийлэнх олонх нь буддын шашинтай явж ирсэн тул байгаль дэлхий, мал сүрэг, ан амьтнаа хамгаалах сүсэг бишрэлийн уламжлал түүнтэй салиггүй холбоотой хөгжжээ. Буддын ёс зүйн сургаал нь хоосон чанар, шүтэн барилдлага, дахин төрөх, хүч үл хэрэглэх, зовлон, таван сахил, дөрвөн үнэний сургаал, зөв найман зам мөр, дөрвөн цаглашгүй, хэм хэмжээ, буян нүгэл, үйлийн үр, гэгээрэл, нисванис зэрэг ойлголт, үзэл санаанд тулгуурладаг.

Түлхүүр үг: Дөрвөн үнэн, зөв мөр, таван сахил, зургаан барамид, асрах энэрэх сэтгэл, баясах сэтгэл, тэгш хандах сэтгэл, үйлийн үр, ахимса, ан амьтан.

Амьтныг хамгаалах ёс зүй (Animal ethics) нь хэрэглээний ёс зүйн нэгэн чиглэл бөгөөд хүн ба амьтны хоорондын харилцаа, хүнээс амьтантай хэрхэн харилцах, хамгаалах ёс суртахууны асуудлыг авч үздэг. Амьтны жам ёсны эрх, амьтан тэжээх, амьтныг хамгаалах тухай эрх зүйн зохицуулалт, амьтны зан үйл, зэрлэг амьтдын хамгааллыг чухалчлахын зэрэгцээ энэрэнгүй ёсоор амьтанд хандах хэм хэмжээ, зарчим, арга замыг судална.

Амьтныг хамгаалах ёс зүйн чиглэлийн орчин үеийн томоохон төлөөлөгч бол Австралийн философич, Принстоны Их сургуулийн био ёс зүйн профессор Питер Альберт Дэвид Зингер (1946-) юм. Тэрээр

хэрэглээний ёс зүйгээр дагнан мэргэшсэн нэгэн бөгөөд ёс зүйн асуудалд ихэвчлэн утилитар үзлийн үүднээс ханддаг. Зингер “Амьтдыг чөлөөлөхүй” (1975) бүтээлээрээ алдартай. “Ихэнх Америкчуудын хувьд нэг бүлгийн гишүүн нь өөр бүлгийн гишүүнийг өмчлөх нь хэвийн бөгөөд ёс суртахууны хувьд зөв хэмээн боддог байсан үе бий. Харин өнөөдөр өмнөх үеийн тэрхүү хандлагаас ичиж зовдог”¹ хэмээн бичжээ. Зингер хойч үе биднийг хэрхэн амьдарч, юу үлдээснийг эргэж харахдаа амьтдад хэрхэн хандаж байгааг дээрхтэй адил харьцуулж үнэлэх цаг үе ирнэ хэмээсэн байдаг. Иймээс Зингерийн үзлийн үүднээс, хойч үеэсээ ичиж гутрахгүйн тулд бид амьтдад хэрхэн хандах ёстой вэ? Энэ асуултад буддын

¹ Peter Singer. Practical ethics. Third edition. Cambridge University Press. 2011. p 95

ёс зүйд хэрхэн хариулт өгдгийг авч үзэн өгүүлийнхээ үндсэн асуудалд оръё.

Буддын ёс зүйн үзэл нь энэрэн нигүүлсэхүйн зарчим дээр тулгуурлаж, эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд байж, хорхой шавжаас эхлээд бүх амьтныг хайрлаж хамгаалахыг сургадаг болохыг дээр тэмдэглэсэн.

Бурхан багшийн айлдсан хутагтын дөрвөн үнэн буюу 1.Зовлон үнэн, 2.Зовлонгийн шалтгаан үнэн, 3.Зовлонг гэтлэх нь үнэн, 4. Зовлонгоос гэтлэх зам мөр үнэн гэсэн сургаалд зовлонгоос гэтлэж, жаргалд хүрэх замыг зааж өгсөн байдаг. Буддизмд зовлонгоос гэтлэхийн тулд хамаг амьтны тусыг үйлдэх ёстой гэж сургана.

1. Зовлон үнэн хэмээх сургаалаа дараах байдлаар тайлбарласан байна. Тэрээр хүний төрөх, өвдөх, хөгшрөх, үхэх зовлонгоос гадна амьтны зовлонг ажиглан, амьтдад энэрэнгүй сэтгэлээр ханддаг байжээ. Тухайлбал: Сиддхарта эргэн тойронд байгаа амьтдыг ажиглав. Нэг гүрвэл шоргоолж идэж байхыг эхлээд харж гэнэ. Гэтэл нэг могой гарч ирээд гүрвэлийг залгиж орхив. Гэвч удалгүй тэнгэрээс нэгэн том шувуу шумбан бууж ирээд нөгөө могойг шүүрэн одов гэнэ. Орчлонгийн бүх амьтан түр нэгэн хэсэг жаргалтай юм шиг харагдаж байв ч эцэстээ з о в л о н м ө х л ө ө р д у у с д а г и й г Сиддхарта үүнээс ойлгосон тухай өгүүлдэг.
2. Тэрээр аливаа зовлонгийн шалтгаан нь шуна л т а ч а а л, уур хилэн, мунхгаас үүдэлтэй гэж хоёр дахь үнэний сургаалдаа айлджээ.
3. Гурав дахь үнэний сургаалдаа шун а л, уур, мунхгийг дарж зовлонгоос ангижирч нирваан / шунал, мунхралаас ангижирч

гэгээрэл/-д хүрч болно гэж сургасан буй.

4. Буддагийн зовлонгоос ангижрах мөрд хөтлөх найм ан зөв зам мөрийн сургаалд 1.Зөв үзэл, 2.Зөв бодол, 3. Зөв үг яриа, 4. Зөв үйл,5.Зөв амьдрал, 6.Зөв хичээл, 7.Зөв дурдатгал, 8.Зөв бясалгал ордог. Аливаа хүн эдгээр найман зөв зам мөрийг баримталснаар хүрээлэх орчиндоо ээлтэй, түүнийг хамгаалж амьдрах дадлыг хэвшүүлэх юм. Буддизмд “амьтны амь хөнөөх нүгэлт муу үйл үйлдсэнээр нас ахар болох, хэрцгий догшин болж царай зүс алдах, байнга өвчинд нэрвэгдэх, эд мал хорогдох үр дагавартай”² гэж номлодог. Зөв үйлийн сургаалыг дагаж амьтныг хамгаалбал нас буян арвижна. Түүнчлэн зөв амьдралын хэв маягийг сонгож галт зэвсэг, үй олноор хөнөөх зэвсэг, мансууруулах ундаа, хорт бодис худалдаалах, амьтан хөнөөх ажил үйл эрхлэхгүй байх нь амьтны эрхийг хамгаалж буй хэлбэр болно.

Будда амьтныг хайрлахыг сургаад зогсохгүй биеэрээ үлгэрлэн үзүүлдэг байжээ. Түүний намтарт амьтны зовлонг ажиглан, тэднийг хайрлан, хамгаалж буй дараах үйл явдал гардаг. Үүнд:

1. Бүх амьтан өвчин зовлонг хүсдэггүй, амар амгалан амьдрахыг хүсдэг болохыг бага наснаасаа ойлгож, тэдэнд найрсаг ханддаг байдлаараа үлгэрлэдэг байжээ.
2. Нэгэн өдөр бяцхан хүүхэд саваагаар могой цохиж байхыг харжээ. Ханхүү тэр даруй түүнийг хориглон, могойг гэмтээж болохгүй гэж хэлсэн байна.
3. Сиддх ар та ханхүүгийн үе э л Девадатта нэгэн хун шувууг нум сумаар харван унагаж гэнэ. Шувуу

² Булган.Т. Буддын ёс зүй, гүн ухааны суртгаалийн эмхэтгэл, УБ., 2016. 202-205 дахь тал.

маш хүнд шархадс ан байлаа. Сиддхарта шархадсан шувууны зүг гүйж очоод түүний гараараа илж тайвшруулаад, сумыг нь салган авч, цусыг нь тогтоон асарчээ. Девадатта: “Миний харваж унагасан хун шувууг на дад өг” гэхэд, Сиддхарта: “Би чамд энэ шувууг өгөхгүй. Хэрэв чи энэ шувууг алсан бол чинийх болно, харин энэ шувуу одоо шархадсан, амьд байна. Би түүний амийг аварсан болохоор энэ миний шувуу болно” хэмээн шувууг аварчээ.

4. Сиддхарта газар хагалах ёслолд очихдоо анжсанд хөллөгдсөн үхрүүд маш их ядарсан зовсонг хараад энэрэх сэтгэл төржээ.

Бурхан багш анхлан амьтнаар тахил өргөх, өөрсдийнхөө сайн сайхны төлөө нэрээр амьтны амь таслах зэрэг бурангуй үйлдлийг эсэргүүцэж, сургаал номлолоо айлдаж байсан түүхтэй. Амьтад хүний сайн сайхны төлөө зориулагдаагүй болохыг тэрээр онцолж байв. “Орчин үед байгаль орчны төлөө тэмцэгчид хүний эх захгүй хэрэглээг шүтэх үзэл, шунал, шинжлэх ухаан, технологийн дэвшлийг буруу ашигласнаас болж байгаль орчны тэнцвэрт байдал алдагдаж байна”³ Хүний эх захгүй шунал, хэрэглээ нь хүрээлэх орчинтой зохисгүй харилцах, бүтээх сэтгэлгээнээс илүү хэрэглэх сэтгэлгээг шүтэх болсон зэрэг амьдралын буруу хэв маягийг бий болгож байгаа бөгөөд эргээд биднийг сав шим ертөнцдөө төвлөрч, зохистой амьдрах хэлбэрийг эрхэмлэхийг шаардаж байна.

Юмс бие биеэсээ хамаарч шүтэн барилдаж оршино. Тэр нь эмх цэгцтэй, зүй тогтолтой. Шүтэн барилдлага, эмх цэгц, зүй тогтол зэрэг энэ бүхэн бол юмсын орших байдал мөн. Бусдаас хамаарахгүй оршдог зүйл гэж үгүй. Ганцаараа, бусдаас үл хамааран бие даан оршигч гэж үгүй.

Буддистууд одоо амьдралд өрнөж буй бүхэн шүтэн барилдаж гарсан бөгөөд энэ нь зайлшгүй гэдэгт итгэдэг. Түүнчлэн ирээдүйд ч юмс шүтэн барилдаж гарна. Хүн амьтныг хэрэглэх биш, харин ижил байр сууринд байх хэрэгтэй гэж үздэг.

Бид хүний эрхийн тухай их ярьдаг боловч хожим амьтны эрхийн тухай түлхүү ярих болсон. Харин буддын ёс зүйн сургаалд амьтныг хүндэтгэж харьцахыг эртнээс сургаж иржээ. Буддын ёс зүйн сургаалд “Дөрвөн цаглашгүй” хэмээх үзэл байдаг. Тэрхүү үзэл нь амьтныг хамгаалах тухай үзэл санааг багтаадаг бөгөөд:

Нэгдүгээрт, асрахуй сэтгэлээр хандах: Хайр энэрлийн үндэс нь эх хүн байдаг. Тиймээс а) хамаг амьтныг “эх” гэж бясалгах б) эхийн ачийг санах в) эхийн ачийг хариулах гэсэн бодлыг үүсгэх явдал юм. Эхийн ачийг хариулах лугаа адил амьтан бүрд асрах сэтгэлээр хандахыг сургадаг. Энэ тухай “Өнчин янзаганы үг”⁴-ээс харж болох бөгөөд тэнд:

“... Ачтай ээжээ алуулснаас
Аюултай зовлонгоор нэрмэгдээд
Арын ой цэцэрлэгт тэнүүчлэн гүйж
Амиа гэжээхийн эрхээр ядарч зүдэрчээ.
Ээжийгээ үгүйлэн уйлснаас
Эргэж үүгээр түүгээр, дэгдэн гүйж эрсэн
боловч
Эмгэнэн жихүүр гэмшиж айж явсаар
Элмэрч тэнэн зовжээ...” хэмээн
өгүүлжээ.

Үүгээрээ амьтныг хайрлах, бусдыг өөртэйгөө жишиж бодох тухай хүмүүжлийн ач холбогдолтой санааг тусгасан байна. Энэ нь орчин үеийн бидний зорьж буй “Бусдын оронд өөрийгөө тавин бодож, нөгөө талаас харах” /empathy/ чадварыг илэрхийлсэн хэрэг болно.

Хоёрдугаарт, нигүүлсэхүй сэтгэлээр хандах: “Битгий зовоосой” хэмээн зовлонгоос ангижруулах хүслийг

³ Дэмбэрэл.С. Дээрхийн гэгээн XIV Далай ламын нэгэн зохиолд ногоон ёс зүйн үзэл санаа илрэх нь. Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.,2019. 104 дэх тал.

⁴ Алтан хүрдэн. Эмх. Хүрэлбаатар Л. УБ.,1992.

нигүүлсэх сэтгэл хэмээдэг. Амьтад хүчтэй нь хүчгүйгээ барихаас гадна үргэлжийн алуулж хөнөөгдөх, өлсөж цангах, халуун хүйтнийг давах, элдэв янзаар анчин гөрөөчинд хороолгох зэргээр цаг үргэлжид зовж байдаг. Иймээс энэрэнгүй байж, элдэв нөхцөл тавихгүйгээр өрөвдөн хайрлах чадвар /compassion/, амьтныг үл хорлох сэтгэлийг бий болгох нь чухал юм. Энэ тухай:

“Алагдах газраа одогсдыг сайтар
чөлөөлөх
Амь биеэр туслах хийгээд
Амьтны аюулаас аврах зэргээр
Ашид урт наслах буюу
Өвчтөн хүнийг өргөж амрах
Эм тан, эмч отчоор туслах
Саваа мод, шороо чулуу зэргээр
Амьтныг эс хөнөөвөөс өвчингүй буюу
хэмээн”⁵ хэмээн зохиолд өгүүлжээ.

Гуравдугаарт, баясахуй сэтгэлээр хандах: Бусдын амжилт, сайн сайханд баясаж, тэдний амар амгалан буйд талархан хандах сэтгэл юм. Ийм хандлага нь өөрийн сэтгэлийг өөдрөг байлгах, өвчин тусахгүй байх, буян хураах үндэс болно. Би ганцаар амжилттай, амар амгалан байгаадаа ханах бус, амьтан бүр зовлонгүй үргэлж амгалан байхыг хүсэх, тийм байгааг харах нь баясах сэтгэл болно.

Дөрөвдүгээрт, тэгш сэтгэлээр хандах: Мунхаг сэтгэлээс болж хүн бусдыг дээр доор, бид тэд, манай танай хэмээн ялгаварлан дорд үзэх, зусардах, ая тал засах гэх мэт хуурмаг дүрийг бий болгодог. Өөрийн гэлтгүй хамаг амьтанд алагчлалгүй хандахыг тэгш сэтгэл үүсгэх хэмээдэг. Жишээлбэл, бусдын малыг хаяад өөрийн малыг услах нь алагчлах сэтгэл юм.

Дөрвөн цаглашгүй тус бүрийг өөрийн сэтгэлд үүсгэх хийн тулд “Зовлонгийн үндэс болсон мунхаг, уур, шунал гэсэн нисваанисаас хамаг амьтад хагацаасай, тэдгээрийг дарах арга болох

билгүүн ухаан, хүлцэл тэвчээр, өгөөмөр сэтгэлийг амьтан бүгдэд би төрүүлэн үйлдье. Тийнхүү үйлдэж чадахад багш минь та адислан хайрла” хэмээн бясалгадаг ажээ. Цаглашгүй дөрвөн сэтгэлийг үүсгэхэд:

“Хамаг амьтан амгалан хийгээд
амгалангийн шалтгааныг төгс олох
болтугай.

Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийн шалтгаанаас эгнэгт хагацах болтугай.

Хамаг амьтан зовлон үгүй, амгалангаас хэзээд үл хагацах болтугай.

Хамаг амьтан ойр, хол садагнан тачаах, өслөн уурлах аль алианаас ангид тэгш сэтгэлээр орших болтугай” хэмээн залбирдаг байна.

Амьтан амгалантай учраасай, зовлонгоос хагацаасай хэмээх асрахуй, нигүүлсэхүй сэтгэл нь хамаг амьтныг амгалан болгох зорилготой тул аливаа хүн тийм сэтгэлийг өөртөө төрүүлэх хэрэгтэй.

Буддизм хайр, энэрэл нигүүлслийг сургадаг, хүчирхийлэлгүй байхын төлөө бүх үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Иймээс энэ сургаал ан амьтан, байгаль орчныг хамгаалахад чухал ач холбогдолтой. Буддистууд ахимса /ahimsa/-д итгэдэг. Тэр нь шалтгаангүйгээр амьтан алахыг цээрлэж, харин амьтдад байж болох хамгийн сайн орчныг бүрдүүлж өгөх явдал юм. Түүнчлэн амьтад бол буддын шашны чухал бэлгэ тэмдэг байдаг. Тухайлбал, арслан хүчирхгийн, заан гэгээрэлд хүрэхэд шаардлагатай оюун ухааны хүч чадал, уян хатан байдлын, морь нь цог хийморь, эрч хүчний, гөрөөс бодь сэтгэлийн бэлгэдэл тус тус болдог байна.

10 хар нүгэл дотроос амьтны амь таслах, буруу үзэл хоёр хамгийн их хор хөнөөлтэй байдгийг сургадаг. Тухайлбал,

“Амь таслахаас дээш хилэнц үгүй
Арван хар нүглээс илүү буруу үзэл

⁵ Зонхова Лувсандагва. Их бодь мөрийн зэрэг. УБ., 2004. Орч., Т.Булган.

үгүй”⁶ гэдэг.

Бурхан багш өөрийн шавь нартаа таван сахилыг мөрдлөг болгохыг захидаг байжээ. Үүнд:

- Амьтны амь үл таслах
- Хулгай хийхгүй байх
- Буруу үл хурьцах
- Худал хэлэхгүй байх
- Архи дарс уухгүй байх эдгээр болно.

Эдгээрээс амьтны эрхтэй холбоотой сахил нь амь үл таслах болно. Амьтны амь таслах нь дараах таван нөхцөл шалтгаан бүрдэж үйлдэгдэнэ гэж үздэг.

1. Суурь нь өөрөөс үндэс тусдаа амьтан /үндэс угсаа, гарал үүсэл өөр/
2. Санаа нь амь таслах амьтныг мэдсэн ба эндүүрээгүй /санаатай үйл/
3. Үйлд эл нь хор, м эс, х араа л тэргүүтнээр өөрөө алах юм уу, бусдаар үйлдүүлэх
4. Муу сэтгэл нь хүсэл шунал, уур, мунхаг гурваас үүдэх ч ялангуяа уураас болж амьтны амийг ихэвчлэн бүрэлгэдэг
5. Эцэс төгсгөл буюу үр дүнд нь амьтан байгалийн жам ёсоор үхэхээс өмнө муу үйл үйлдэгдэнэ.

Амьтны амь т аслахыг дараах байдлаар гурав ангилдаг. Шуналын үүднээс амьтны арьс, маханд шунаж амь таслах, уур хилэнгийн үүднээс өшөө хонзон санаж амьтны амь таслах, мунхгийн үүднээс хонь малаар тахил үйлдэх гэж хуваана.

Буддизмд амьтны амь таслахын эсрэг үл хорлох, хүчирхийлэл үл үйлдэх (ахимса) зарчмыг баримтална. Өөртэйгөө адил ямар ч амьтан өвчин шаналал, үхлийг хүсд эггүйг ойлгож, ухаарч амьтныг хайрлаж энэрэн, хор хүргэхээс зайлсхийх ёстой гэх үзэл дээр хүчирхийлэл үл үйлдэх зарчим суурилдаг. Буддизмд амьтнаар тахил өргөхийн оронд цэцэг, чихэр жимс, хүнсний ногоо, сүү, тараг, цагаан идээгээр тахил

өргөхийг эрхэмлэдэг. Мөн буддын шашны лам нар зун, борооны улиралд жижиг өт хорхой өсөж үржих үеэр ундны усаа шүүж хэрэглэн, гадуур явалгүй сүм хийддээ бясалгаж өнгөрөөдөг уламжлалтай.

Буддын шашны сургаал номлолыг амьдралдаа хэрэгжүүлэхэд зургаан билиг барамидыг дадуулах ёстой. Тэрхүү зургаан билиг барамидад 1.Өглөг, 2. Шагшаабад буюу ёс суртахуун, 3 .Хүлцэнгүй, 4. Хичээнгүй, 5.Дияан, 6. Билиг барамид зэрэг ордог. Барамид нь чинад хязгаарт хүрэх, төгс төгөлдөр боловсрох гэсэн утгатай санскрит үг юм. Эдгээр барамид тус бүрийн агуулга нь өгүүллийн үндсэн санаатай хэрхэн холбогдохыг авч үзье. Үүнд:

Нэгдүгээрт, өглөгийн барамид нь номын өглөг, аюулгүй өглөг, эд материалын өглөг гэсэн гурван хэлбэртэй бөгөөд аюулгүй өглөг нь амьтны амь аврах, үл хорлох, үл хүчирхийлэх, хайрлах, хамгаалалтад авахыг хэлнэ. Аюулгүй өглөгийг амьдралд хэрэгжүүлэхдээ амьтныг айдас түгшүүр, аюултай нөхцөл байдлаас гаргаж, асарч хамгаалах хэрэгтэй. Мөн энэ өглөгийг амьдралд хэрэгжүүлэх нэг арга зам нь махан хоолноос татгалзах, мацаг барих, цагаан хоол хүнсэндээ хэрэглэхийг эрхэмлэх ёстой гэж сургадаг.

Хоёрдугаарт, шагшаабад буюу ёс суртахууны барамидыг (төгс төлөвшилийг) дадуулахад хамаг амьтныг энэр эх хамгаалах хуврагийн болон бодьсадвын сахил санваарыг дагах, байгалийн хууль, ард түмний амьтан хамгаалах ёс уламжлал, дүрэм, журам, хуулийг ёсчлон хэрэгжүүлэх асуудал чухал юм.

Гуравдугаарт, хүлцэнгүй буюу тэвчээрийн төгс төлөвшил нь амьтныг хамгаалах үйлсэд тулгарч болох аливаа асуудал бэрхшээлд шантралгүй, тэвчээртэй хандах, амьтан өөрийн мөн чанараар догшин авир гаргасан ч түүнийг нь хүлцэж, тэвчиж сурахад дадуулдаг. Будда энэ тухай

⁶Бодь мөрийн зэрэг. УБ.,2009. 239 дэх тал.

“Амьтан биеэ хамгаалж архирч, догшин зан гаргах түүний араншин, харин түүнийг байгаагаар нь хайрлаж энэрэх нь зөвхөн хүний мөн чанар байх болно” хэмээн сургасан. Амьтныг хамгаалахад бусад хүн үг хэл, үйлдэл зэрэг элдвээр саад хийх, эсвэл байгаль, цаг агаарын хүнд нөхцөл, байгалийн гамшиг тохиолдож саад болох, өөрийн амьдрал, бие сэтгэлд учирч буй зовлон бэрхшээлийг тэвчиж, хүлцэн амьтныг хамгаалах үйлсдээ тууштай байх ёстой.

Дөрөвдүгээрт, хичээнгүй барамидыг дадуулахдаа амьтныг хамгаалах үйлсдээ гаргасан амжилтаа бататган, илүү хичээл зүтгэл гаргаж, амьтан хамгаалах орчинн өхц өли й г т асра лтг үй с ай жруулах хэрэгтэй.

Тавдугаарт, дияаны барамид нь аливаа хийж буй үйлдэлдээ сэтгэлээ төвлөрүүлж, нэгэн үзүүрт сэтгэлээр түүндээ хандвал амжилт, сайн үр дагавар гарах талаар сургадаг. Амьтны эрхийг хамгаалах үйлсэд ч мөн сэтгэлээ төвлөрүүлснээр амжилт гарч болно.

Зургаадугаарт, билгүүний билиг барамид нь ертөнцийн аливаа зүйлс хүн, амьтан, ургамал хоорондоо шүтэн барилдаж оршдогийг ойлгож ухаарч, ялг ав ар л а л, г адуурх а л үүсг эхг үй бодьсадвын сэтгэл үүсгэхийг чухалчилж, өдөр тутамдаа дадуулах нь чухал хэмээн сургадаг.

Түүнчлэн буддын ёс зүйд сэтгэлээр үйлдэх гурван нүгэл⁷ -д:

- Ховдог шунахай сэтгэл
- Хорлох сэтгэл
- Буруу үзэл гурвыг нэрлэжээ.

Энэ бүх сэтгэлийн мууг арилгахгүй аваас хүнээс авхуулаад амьтныг хүртэл амар амьдруулах нөхцөл бүрдүүлдэггүй. Өөрөөр хэлбэл, эцсийн дүндээ өөрийгөө

амар тайван амьдрах боломжийг ч үгүй хийдэг гэж ойлгож болно.

“Энэ хорвоод “өөрийн” гэсэн юу ч байхгүй. Бүх юм цаг нь болж, нөхцөл бүрдэхэд хүнд олдож, хүн түүнийг түр хугацаагаар хэрэглэнэ. Иймээс аливаад дээд зэргээр ариг гамтай хандах ёстой”⁸ хэмээнэ. Үнэхээр ч бид оршихуйдаа ээлгүй хандаж амьдарснаар өнөөдөр байгаль дэлхийн баян тансаг байдал алдагдаж, тэр хэрээрээ хүний амьдрал улам бүр доройтсоор байна. Ховор амьтдын жагсаалт жил ирэх бүр нэмэгдэж, байгаль экологийн зүй тогтол алдагдсаар байна. Энэ бүхэн нь буддын ёс зүйн сургаалын үүднээс буруу муу сэтгэлээс үүдэж буй юм. Хүмүүн бидний шунахай зан, энэрэх нигүүлсэлгүй сэтгэл, мунхаг харанхуй байдал энэ хэвээр үргэлжлэх юм бол ирээдүйн амьдрал улам бүр дордох болно.

Буддын сургаалд онцлон шүүмжлэлтэй ханддаг нэг зүйл бол амьтдын талаарх хүний үнэлэмж юм. Амьтдын амьдралыг үнэлэх цорын ганц шалгуурыг хүмүүс “хэрэгцээтэй зүйл” гэж үздэг явдал юм. Ингэснээрээ хүмүүс амьтдад хайхрамжгүй, харгис ханддаг. Тэр ч байтугай зугаацах зорилгоор зэрлэг амьтдыг устгах, амьтдаас илүү чадварлаг, хүчирхэг гэдгээ харуулж, гэм зэмгүй амьтдыг ч алах тохиолдол байдаг. Иймээс аливаа амьтдыг хэрэгцээ талаас нь харахдаа болгоомжтой байхыг уриалж, хэрэглээгээ зөв зохистой зохицуулахыг сургадаг. Амьтнаар тахил өргөхийг цээрлэдэг. Гэм зэмгүй амьтнаар тахил өргөснөөр хүний амьдрал дээшилдэг гэж үзвэл үүн шиг мунхаг харанхуй зүйл байхгүйг сургасан байдаг.

Ан амьтан хамгаалах чиглэлээр орчин үеийн буддистууд их зүйлийг хийсээр ирсний нэг нь “Буддистуудын байгалийн тухай тунхаглал” юм. Тэрхүү тунхаглалын гол санааг товчлон сийрүүлье.

⁷ Богд Зонхова. Бодь мөрийн зэрэг. УБ.,2002. Орч.,Г.Пүрэвбат. 252-253 дахь талд.

⁸ Бурхан багшийн сургаал. УБ.,1996. 235 дахь тал.

Хүмүүс оршин амьдрах аа маргашгүй эрх гэж үздэг. “Хүн бүр амьд явах эрхтэй” хэмээн үндсэн хуульдаа тунхагладаг. Түүнчлэн “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна”, “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” хэмээн хүний эрхийн түгээмэл тунхаглалд ч заасан буй. Тэгвэл бусад амьтны хувьд ч гэсэн оршин амьдрах эрхтэй байх нь чухал хэрэг. Хүн төрөлхтөн болон бусад хүмүүн биш амьд оршихуйнууд хүрээлэн буй орчны сайн сайхан байдлаас хамаардаг тул өнгөрсөн хугацаанд бидний хайхрамжгүй байдлаас үүдсэн гарз хохиролдоо дүгнэлт хийж, байгаль орчноо хамгаалах зоригтой, шийдэмгий алхмуудыг хэрэгжүүлэх ёстой хэмээн үзсэн байна.

Дүгнэлт

Буддын ёс зүй дэх амьтныг хамгаалах сургаалын гол агуулга нь:

- 1) Амьтан ч ялгаагүй, хүн ч ялгаагүй бүгд сайн сайхан амьдрах эрхтэй.
- 2) Энэ ертөнцийн хамгийн дээд буян бол энэрэл нигүүлсэл бөгөөд бид түүнийг ямар ч цаг үед бүхий л төрөлтнүүдэд үзүүлэх ёстой.
- 3) Аливаа амьтанд зовлон, үхэл хагацал учруулахгүй байхын тулд бид чадах бүхнээ хийх ёстой.
- 4) Хамаг амьтан аюулын өмнө хүчин мөхөстдөг, аюулаас айдаг. Бүгд үхлээс айдаг. Амьтан алахгүй, аллагын шинжтэй аливаа үйл ажиллагааг дэмжихгүй байх сонголтыг хүн бүр хийж чадна. Иймээс амьдралд хүндэтгэлтэй, энэрэл нигүүлсэнгүй хандаж амьдарч сурахыг чухалчилдаг.

Байгалийн нөөц баялгийг үгүйрүүлж хоосруулж буй хүчин зүйлд үл тоомсорлох байдал нь өнөөдөр бидний өмнө аюул

заналыг бий болгож, түүнчлэн ховордсон амьтдын амьдрах боломжийг үгүй хийж байна. Байгаль орчныг сүйтгэснээр түүнээс хамааралтай эмзэг амьдралыг бий болгож байна. Бүх амьд зүйлийн амьдралыг бусниулж, баялгийг цөлмөж, шуналдаа баригдаж, оршихуйг үл тоомсорлосны үр дүнд өнөөдрийн экологийн доройтол нэгэнт бодит байдал болсон. Хэрэв энэ дэлхийд амар амгалан, энх тайван нь бодит байдал болж чадахгүй, байгаль орчны сүйрэл өнөөдрийнх шиг үргэлжилсээр байвал ирээдүй хойч үе “үхсэн ертөнц”-ийг өвлөн авах нь эргэлзээгүй болно. Өвөг дээдэс бидний хэрэгцээг хангах нөөц баялгийг үлдээсэн. Энэ бол баримт. Бид өмнө нь байгалийн нөөц баялаг хязгааргүй гэж бодож ирсэн. Ийм мунхаг байдлаас болж өнөөдөр бид хэцүү байдалд амьдарч байна. Иймээс үүнийг одоо л ухамсарлаж, үүрэг хариуцлагаа ухамсарлаж, үнэт сургаалын утга учрыг тунгааж, зөв үйлд тууштай хандаж, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх дэлхий ертөнцийг бодох цаг ирсэн.

Ном зүй

Монгол хэл дээр

1. Алтан хүрдэн. Эмх. Хүрэлбаатар Л. УБ.,1992.
2. Баярчимэг.Ч, Золзаяа.М, Оюунгэрэл. Д. Монголчуудын амьтныг хамгаалах ёс суртахууны уламжлал ба шинэчлэл. УБ.,2020.
3. Бодь мөрийн зэрэг. УБ.,2009
4. Булган.Т. Буддын ёс зүй, гүн ухааны сургаалийн эмхэтгэл, УБ., 2016
5. Бурхан багшийн сургаал. Орч.,Энхбаяр.Н. УБ.,1996.
6. Гантуяа.М. Буддын философи судлалын зарим асуудал. УБ.,2004.
7. Гантуяа.М, Дагвадорж.Д, Жамбал. А. Шашин судлал. Хоёр дахь хэвлэл. УБ.,2019
8. XIV Далай лам Данзанжамц, Шинэ оюунтны нүдийг нээх сайн номлол хэмээгч оршвой, орч С.Гантөмөр, эрхлэн гаргасан Жавзандамба хутагт төв, Мөнхийн үсэг ХХК, УБ, 2013.

9. Бурхан багшийн намтар, Орч., Г.Мягмарсүрэн, УБ., 2011.
10. Дарьхүү Р. Ёс зүйн асуудлууд. УБ.,2015
11. Дарьхүү Р., Золзаяа М., Оюунгэрэл Д. Ёс сурт ахууны боловсрол. УБ.,2014.
12. Ёс зүй, био ёс зүйн үндс эн асуудлууд. ЭШБХ-ын эмхэтгэл. УБ.,2017.
13. Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй. Ёс зүйн эрдэм шинжилгээний 6 дахьхурлын эмхэтгэл УБ.,2019
14. Хайр энэрлийн үр. Дээрхийн Гэгээнтэн Далай ламын амьдрал, сургаалаас авах сургамж. Орч., Дэмбэрэл.С. УБ.,2021
15. Чоймаа Ш., Янжинс үрэн С.Сэтгэлийг ариусгахуй. УБ.,

Англи хэл дээр

1. Venerable Master Chin Kung, Buddhism: The Awakening of Compassion and Wisdom, Taiwan, R.O.C, 2008
2. Buddhist Ethics. A very short Introduction. Oxford University Press. 2005.
3. Buddhist Normative Ethics. By Chao- hwei Shih. Taiwan 2014.
4. Peter Singer. Practical ethics. Third edition. Cambridge University Press.2011.
5. Philosophers take on the world. Edited by David Edmonds. Oxford University Press.,2018.

Abstract: Bioethic is the trend of modern applied ethics, which search for the resolving method of how to deal with problems and issues facing humankind. As an example, diversity of plants and animals, medical ethics, biosecurity, neuro ethics, animal right, genetic engineering, stem cell, embryo transfer, cloning, sexual minority issues belong to the bioethics. The article will highlight topics of Buddhist ethics considered on animal ethics, animal rights, which are main topics of ongoing discussion. Buddhism is an indivisible part of culture and thought of humanity, its teaching and rituals provide the defining and guiding ethics on human- nature relationships.

Buddhist ethics is based on the principle of compassion, which teaches to protect and preserve all sentient beings, for the benefit of all living beings, including tiny insects. The majority of Mongolians are buddhists, therefore, mongolian spiritual tradition of protecting the environment, livestock and wild animals is related to Buddhist teaching. The cornerstone of Buddhist ethics to include concepts of impermanence, interdependent nature of all sentient beings, rebirth, non-violence, sufferings, four noble truths, eight noble paths, five precepts, four immeasurables, moral, virtues and unwholesome deeds, karma, defilements, enlightenment etc.